

## БҮГД НАЙРАМДАХ СОЦИАЛИСТ ВЬЕТНАМ УЛСАД БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРТ СУРАЛЦАХ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

### I. Тавигдах шаардлага

1. Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангид суралцдаг Монгол Улсын иргэн бол тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргаж буй жилийн суралцаж байгаа хугацааны дүнгийн хуулбар 80+ буюу түүнээс дээш байх
2. Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, коллежийн I-II курст суралцагч Монгол Улсын иргэн бол голч дүн 3.0 ба түүнээс дээш голч дүнтэй байх
3. Өөр улсын Засгийн газрын тэтгэлэгт хамрагдаагүй байх

### II. Суралцах мэргэжлийн чиглэл, хяналтын тооны тухай

- Олон улсын харилцаа,
- Аялал жуулчлал,
- Хүнсний инженерчлэл,
- Анагаах ухаан,
- Соёлын өвийн сэргээн засварлах,
- Усны нөөцийн менежмент,
- Сэргээгдэх эрчим хүч

Дээрх суралцах мэргэжлийн үндсэн чиглэл тухайн жилийн ажлын байрны эрэлт хэрэгцээ шаардлагаас хамаарч өөрчлөгдөх магадлалтай бөгөөд жил бүр өөр байж болно. Мөн хяналтын тоонд багтаан жил бүр тус тэтгэлэгт хөтөлбөрт хамруулан суралцуулах элсэгчийн тоо янз бүр байна.

### III. Бүртгэл: Жил бүрийн III-IV сард явагддаг.

<https://scholarship.esis.edu.mn/> холбоосоор хандан, хэрэглэгчийн эрх үүсгэн нэвтэрч, цахим өргөдлийг бөглөх, илгээх гарын авлагатай танилцан, өргөдлийг бөглөж илгээнэ.

Өргөдөлд дурдсан дараах баримт бичиг тус бүрийг PDF /1 файлын хэмжээ 5Mb-аас ихгүй байх/ хэлбэрээр “баримт бичиг” хэсэгт хавсаргана.

### Цахим бүртгэлийн системд байршуулах баримт бичиг:

*Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагч:*

- Цахим өргөдөл
- Анги удирдсан багшийн тодорхойлолт;
- Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад Засгийн газрын тэтгэлгээр суралцах хүсэлтэй байгааг илэрхийлсэн эсээ /Монгол хэлээр 500 дээш үгтэй байх/;
- 11 дүгээр ангийн дүнгийн тодорхойлолт;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Сүүлийн 6 сарын хугацаанд авхуулсан 3\*4 хэмжээтэй цээж зураг цахимаар оруулна

Бүртгэл дуусах цаг дөхөх тусам системийн ачаалал ихэсдэг тул эрт бүртгүүлэхийг зөвлөж байна.

Бүртгэлээс хоцорсон иргэдийг нэмж бүртгэх боломжгүй тул та тогтоосон хугацаанд бүртгүүлнэ үү.

Цахим бүртгэлийн системд үнэн, зөв баримт бичгийг байршуулах шаардлагатай. Баримт бичгийг хуурамчаар үйлдсэн тохиолдолд тэтгэлгийн эрхийг хасна.

#### **IV. Сонгон шалгаруулалт**

Сонгон шалгаруулалт дараах хоёр үе шаттай байна.

1. Баримт бичгийн бүрдүүлэх үе шат: Тэтгэлэгт хөтөлбөр горилогчийн ирүүлсэн бичиг баримтын бүрдэл, эсээний агуулга, ач холбогдол, өөрийгөө илэрхийлсэн байдал зэрэгт үнэлгээ өгнө.
2. Ярилцлагад орох үе шат: Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан сонгон шалгаруулалтын ярилцлагыг цахим хэлбэрээр хийнэ. Цахим ярилцлагын цагийн хуваарь, оролцох иргэдийн нэрсийн жагсаалтыг Боловсрол, шинжлэх ухааны яамны вэбсайтад байршуулна.

Нийт сонгон шалгаруулалтад оролцсон иргэдийг баримт бичгийн бүрдүүлэлт, ярилцлагын нийлбэр оноогоор жагсааж, хамгийн өндөр оноо авсан иргэдэд тэтгэлэг олгоно.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ